

“Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц

“Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газар болон Монголбанк хамтран 2012.10.26-ны өдрөөс хэрэгжүүлж эхлээд байгаа билээ. Энэ хүрээнд:

Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хувьд:

Тус дэд хөтөлбөрийн санхүүжилтийг Монголбанкнаас бүрэн олгож дуусаад байна. Ингэснээр ҮХААЯ-аас сонгогдсон махны нөөцийн менежерүүд 1 жилийн хугацаатай санхүүжилтийн эх үүсвэрийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж байгаа болно.

“Гурилын нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах” хөтөлбөрийн хувьд:

ҮХААЯ-аас гурилын үйлдвэрүүдийг сонгон шалгаруулж, холбогдох гэрээг байгуулсан болно. Монголбанк эхний ээлжинд хүсэлтээ ирүүлээд байгаа Хаан болон Худалдаа Хөгжлийн банкуудтай гэрээ байгуулж, Улаанбаатар гурил ХХК-д дээрх банкуудаар дамжуулан 1 жилийн хугацаатай нийт 24.0 тэрбум төгрөгийн зээлийн шугамыг 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдөр нээсэн болно.

Жич: Дэд хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Монголбанкны цахим хуудасны “Үнийг тогтворжуулах хөтөлбөр” цэснээс (<http://www.mongolbank.mn/pricestability.aspx>) үзнэ үү.